

ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудит хийх үндэслэл: Аймгийн ИТХ-ын захиалга, Аймгийн Аудитын газрын 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн дагуу хийв.

Аудитын ерөнхий дүгнэлт:

Байгууллага алдагдалгүй ажиллах боломжтой байна.

Аудитын нэр:

Төв Чандмань дулааны эрчим хүчний газрын үйл ажиллагааны байдал



**Зуунмод
2014 он**

АГУУЛГА

<u>Аудитын тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар.....4
ҮАГ-ын харьяа Төв аймгийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт.....5
Дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан	Аудитын дүн.....
Аудитын менежер О.Амаржаргал	БҮЛЭГ -1 Техникийн шинэчлэл хийгдснээр халаах талбайн хэмжээ 25.7 мянган м3-ээр нэмэгдэж, 1м3 талбайг халаах нүүрсний хэмжээ 1.8 кг-аар буурсан боловч нүүрсний үнэ нэмэгдснээс зардал буураагүй байна.....7-13
Аудитор Д.Пүрэвсүрэн	Дүгнэлт 1.1 Байгууллага тусгай зөвшөөрлөө сунгуулаагүй үйл ажиллагаа явуулсан байна.
Шинжээч Ч.Загдсүрэн	Дүгнэлт 1.2 Ажиллагсдын орон тоог нягтруулснаар 63,6 сая төгрөгний цалин, НДШ-ийн зардлыг хэмнэх боломж байна.
2014 оны 02 дугаар сарын 28	Дүгнэлт 1.3 Төлөөлөн удирдах зөвлөл эрх үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, хяналтын зөвлөл огт ажиллаагүй байна.
Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү. http://tuv-audit.mn/	Дүгнэлт 1.4 Техник технологийн шинэчлэл хийснээр 1м3-д зарцуулагдах нүүрсний хэмжээ буурчээ.
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70273463 дугаарын утас, 22582 дугаарын факсаар харилцана уу.	БҮЛЭГ- 2 ТУЗ алдагдалтай ажиллах төлөвлөгөө баталснаас ОНӨҮГ нь батлагдсан төлөвлөгөөний дагуу ашиггүй ажиллаж байна.....14-26
ХАЯГ: Төв аймгийн Төрийн байгууллагын ордон	Дүгнэлт 2.1 Алдагдалтай ажиллах төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажилласан байна.
	Дүгнэлт 2.2 Борлуулалтын орлогыг бүрэн тооцсон байна.
	Дүгнэлт 2.3 Үнэ тарифыг өөрчлөхдөө холбогдох тооцоо судалгааг хангалтгүй хийснээс зохицуулах зөвлөлийн тогтоол шийдвэр хэрэгжихгүй байна.
	Дүгнэлт 2.4 Тээвэр, цалингийн зардлыг бууруулж, үр ашиггүй зардлуудыг хэмнэснээр ашигтай ажиллах боломж байна.
	Дүгнэлт 2.5 Борлуулсан бүтээгдэхүүний өртгийг тооцохдоо удирдлагын зардал болон борлуулалтын

	<i>зардлыг оруулан өртгийг тооцсон байна.</i> Дүгнэлт 2.6 <i>Оны эхнээс авлага 98,2 сая төгрөгөөр, өглөг 176,1 сая төгрөгөөр тус тус өссөн байна.</i> Дүгнэлт 2.7 <i>Өмч хөрөнгөнд бүртгэлтэй дулааны станцын болон уурын зуухны барилга, тоног төхөөрөмжүүд ашиглалтгүй байна.</i> Дүгнэлт.....27 Зөвлөмж.....28 Холбогдох байгууллагын санал: Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал
--	--

Товчилсон үгийн тайлбар

ААГ	Аймгийн аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ДЭХГ	Дулаан эрчим хүчний газар
СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо
УСОС	Ус суваг орон сууц
ДЭХА	Дулаан эрчим хүчний алба
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ДАСА	Дотоод ажил сургалтын алба
СЭЗА	Санхүү эдийн засгийн алба
ЦБ	Цэвэрлэх байгууламж
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
БОНХ	Борлуулалт олон нийттэй харилцах
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
НӨАТ	Нэмэгдсэн өртийн албан татвар
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл
УОО	Урьдчилж орсон орлого
ХБО	Хойшлогдсон борлуулалтын орлого
ХХОАТ	Хувь хүнийн орлогын албан татвар
НБЗГ	Нийтийн бие засах газар
ЭХЗГ	Эрчим хүчний зохицуулах газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилт: Төв Чандмань дулааны эрчим хүчний газрын 2013 оны үйл ажиллагааны байдлыг шалган дүгнэлт, зөвлөмж өгч, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Үүнд:

1. Байгууллага үйл ажиллагаагаа үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?
2. Байгууллага үйл ажиллагаагаа аривлан хэмнэлттэй үр ашигтай хэрэгжүүлж чадсан уу?

Аудитын хамрах хүрээ: Төв Чандмань дулааны эрчим хүчний газар, Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн, хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллагын хүрээнд шалгана.

Аудитын арга зүй: Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглаж аймгийн Ерөнхий аудиторовн баталсан аудитын төлөвлөгөөг мөрдлөг болгон Төв Чандмань ДЭХГазрын 2013 оны үйл ажиллагаатай холбоотой албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, байгууллагын тайлан баримт материалд тулгуурлан тулган шалгах, санхүүгийн болон нөхцөл байдлын шинжилгээ хийхийн зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- ТБОНӨХБҮХАТухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм
- Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм
- Аймаг нийслэлийн зохицуулах зөвлөлийн ажиллах, түүний гишүүнийг томилох журам
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тариф тооцох аргачлал
- Тарифын саналыг хянан шалгах журам
- Аймгийн ИТХ-ын холбогдох тогтоолууд, бусад эрх зүйн актууд

Аудитын стандартын талаархи мэдэгдэл: Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн шалгалтын журам, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол улсын Ерөнхий

аудиторын болон аймгийн Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө хөтөлбөрийг мөрдлөг болгоно.

Аудит хийх бүрэлдэхүүн: Аудитыг аймгийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал удирдан, аудитор Д.Пүрэвсүрэн, шинжээч Ч.Загдсүрэн нар 2014 оны 01-р сарын 06-наас 02-р сарын 28-ныг хүртэл хийж гүйцэтгэв.

Тайлангийн төсөлд санал авахаар Аймгийн Аудитын газрын 2014 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 03/52 тоотоор Төв Чандмань ДЭХГ-т хүргүүлж, Төв Чандмань ДЭХГ-ын 2014 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 80 тоотоор саналаа ирүүлэв.

Бүлэг 1

Техникийн шинэчлэл хийгдснээр халаах талбайн хэмжээ 25.7 мянган м³-ээр нэмэгдэж, 1м³ талбайг халаах нүүрсний хэмжээ 1.8 кг-аар буурсан боловч нүүрсний үнэ нэмэгдснээс зардал буураагүй байна.

1.1. Байгууллага үндсэн чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлж байна уу?

Байгууллага тусгай зөвшөөрлөө сунгуулаагүй үйл ажиллагаа явуулсан байна.

Төв Чандмань ДЭХГазар нь 100 хувь орон нутгийн өмчит байгууллага бөгөөд Зуунмод сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж айл өрх болон аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан дулаан, цэвэр бохир усны, орон сууцанд оршин суугчдад СӨХ-ны үйлчилгээг үзүүлж, айл өрх иргэдэд ундны ус, нийтийн бие засах газрын үйлчилгээг үзүүлж байна.

Тус байгууллага нь Үйлдвэрлэлийн хэсэг, Санхүү эдийн засгийн алба, Борлуулалт олон нийттэй харилцах алба, Дотоод ажил сургалтын алба гэсэн үндсэн 4 албатай, Үйлдвэрлэлийн хэсэг нь УСОС алба, Диспетчерийн алба, ДЭХАлба гэсэн 3 албанд нийт 262 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна.

Дулаан эрчим хүчний алба нь 2013 онд халаалтын 8-н зуухаар 115 аж ахуйн нэгж байгууллагын 33.5 мянган м³, 41 төсөвт байгууллагын 207.7 мянган м³, 1440 айл өрхийн 186.6 мянган м³ талбайг халаах, хэрэглээний халуун усаар хангах үйл ажиллагаа явуулж байна.

Ус суваг орон сууцны алба нь орон сууцнуудын цэвэрлэгээ үйлчилгээг хариуцахаас гадна гүн өрмийн 9 худаг, 2 өргөх станц, нөөцийн 2 усан сан, гэр хорооллын ус түгээдэг 15 усан сангаас жилдээ 550 мянга гаруй тонн усаар хөдөлмөрчдөд үйлчилж, бохир усыг нэгдсэн цэвэрлэх байгууламжаар цэвэршүүлэн зайлуулах ажлыг гүйцэтгэж байна.

Санхүү эдийн засгийн алба нь байгууллагын хөрөнгө санхүүгийн үйл ажиллагааг явуулж, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, түүний зарцуулалтанд хяналт тавих, Борлуулалт олон нийттэй харилцах алба нь дулаан хангамж, цэвэр бохир ус сувагжуулалтын үйлчилгээний борлуулалтын үйл ажиллагааг явуулж байна.

Төв Чандмань ДЭХГ нь дулаан үйлдвэрлэх, хангах, даралтат зуух, сав, шугам хоолойн засвар, угсралт, туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ, барилгын дотор халаалт, усан хангамж ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна шугам сүлжээний угсралт, ус хуримтлуулан ариутгаж түгээх үйл ажиллагаа, нийтийн аж ахуйн нийт 5 тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд “Дулаан үйлдвэрлэх, дулаанаар зохицуулалттай хангах” 01/2010 тоот тусгай зөвшөөрөл нь 2010.05.20-ны өдрөөс 3 жилийн хугацаатай олгогдож 2013.05.20-нд үйл ажиллагаа эрхлэх хугацаа нь дууссан боловч өнөөдрийг хүртэл тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын “Эрчим хүчний тухай” хуулийн 12.1-т “Хуулийн этгээд дараахь үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ” гэсэн байна.

Үүнд. 12.1.2 Дулаан үйлдвэрлэх

12.1.4 Дулаан дамжуулах

12.1.7 Дулаан түгээх үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэхээр заажээ.

Хуулийн “Тусгай зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах” тухай 22.3-т “Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай өргөдлийг тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 180-аас доошгүй хоногийн өмнө гаргана”, 22.4-т “Тусгай зөвшөөрөл нь түүнийг олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно”, 24.3.1-т “Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан үндэслэлээр түүнийг хүчингүй болгоно” гэсэн заалтууд зөрчигдсөн байна.

Мөн “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг”-ийн 25.1.9-д “Цахилгаан дулаан дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цахилгаан дулаан дамжуулах, түгээх сүлжээг өргөтгөх, шинэчлэх талаар 3-5 жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа харилцагч бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчийн саналыг авч, тусгай зөвшөөрөл олгогчид жил бүр тодотгож мэдэгдэх”, 25.1.11-д “үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэх, байгаль хамгаалах, нөхөн сэргээх жил бүрийн төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж мөрдөх” гэсэн заалтууд зөрчигдөж хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон байгаль хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөгүй үйл ажиллагаа явуулсан байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 13 тоот тогтоолоор “Сууц өмчлөгчдийн холбоо”-ны үйл ажиллагааг Төв Чандмань ДЭХГазарт гэрээгээр гүйцэтгүүлэх шийдвэр гарсны дагуу Зуунмод сумын Засаг дарга, Төв Чандмань ДЭХГ-ын гүйцэтгэх захирал нар хамтран ажиллах гэрээ байгуулан хэрэгжүүлж ажиллаж байна.

“Төв Чандмань ДЭХГ” ОНӨҮГ-ын дүрмийг Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2005 оны 07 дугаар сарын 28-ний өдрийн 63 дугаар тогтоолоор баталсан ба өнөөг хүртэл өөрчлөгдөөгүй мөрдөгдөж байгаа нь бусад хууль тогтоомжуудын өөрчлөлт болон өнөөгийн бодит амьдралд хир нийцэж байгааг судалж үзэн шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

1.2. Бүтэц орон тоо нь оновчтой, үр ашигтай зохион байгуулсан уу?

Ажиллагсдын орон тоог нягтруулснаар 63,6 сая төгрөгний цалин, НДШ-ийн зардлыг хэмнэх боломж байна.

Байгууллагын нийт орон тоо гүйцэтгэлээр 2012 онд 266, 2013 онд 264 ажиллагсадтай үйл ажиллагаа явуулсан байна. 2014 онд 262 ажиллагсадтай үйл ажиллагаа явуулж байна. Дээрхи судалгаанаас үзэхэд тайлант онд өнгөрсөн оны гүйцэтгэлээс ДЭХАлба 4 хүнээр, УСОСАлба 1 хүнээр, диспетчерийн алба 1 хүнээр тус тус буурсан, орон сууц 2 хүнээр, усан сан 1 хүнээр өссөн байна.

Төв Чандмань ДЭХГ-ын 2014 оны орон тоо, цалингийн сан

Алба буюу албан тушаал	2012 оны орон тоо	2012 оны цалингийн зардлын гүйцэтгэл	2013 оны орон тоо	2013 оны цалингийн зардлын гүйцэтгэл	2014 оны орон тоо	2014 оны цалингийн зардлын төлөвлөгөө
Удирдлагын алба буюу эдийн засгийн алба	11	65,2	11	73,1	11	92,1
Борлуулалт олон нийттэй харилцах алба	10	56,8	10	66,7	8	80,9
Дотоод ажил сургалтын алба	4	16,8	4	16,9	4	26,2
Үйлдвэрлэлийн алба	241	866,2	239	990,4	239	1389,6
Диспетчерийн алба	13	65,6	13	75,3	15	117,0
Ус суваг орон сууцны алба	76	315,8	78	377,2	82	527,1
Дулааны эрчим хүчний алба	152	484,8	148	537,9	142	745,5
Бүгд ажилчид	266	1005,0	264	1147,1	262	1588,8

Үндсэн үйлдвэрлэл болох халаалтын зууханд 2 инженер, 8 механик, 28 слесарь, 104 машинист ажиллаж байна. Захирал 1, ерөнхий инженер бөгөөд диспетчерийн албаны дарга 1, ерөнхий ня-бо буюу СЭЗАлбаны дарга 1, хүний нөөцийн менежер бөгөөд ДАСАлбаны дарга 1, борлуулалтын ня-бо бөгөөд албаны дарга 1, усан хангамжийн инженер ба албаны дарга 1, дулааны инженер бөгөөд ДЭХАлбаны дарга 1, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн инженер 1, цахилгааны инженер 1, орон сууцны инженер 1, ариутгах татуургын инжежер 1, цэвэрлэх байгууламжийн технологич инжежер 1, цэвэрлэх байгууламжийн хими бактерлогич инженер 1, горим тохируулга засварын инженер 1, эдийн засагч 1, гэсэн нийт 15 удирдлагууд байна. 2014 онд 9 дүгээр зуух татан буугдаж байгаатай холбоотой орон тоо 13 хүнээр буурахаар байгаа боловч 2 хүнээр буурсан байна.

2013 оны гүйцэтгэлээр 264 ажиллагсадтай 1147.1 сая төгрөгийн цалингийн зардал, 149,3 сая төгрөгийн НДШ-ийн зардал гарсан нь 2012 оны гүйцэтгэлээс 2 хүнээр буурч, цалин 142.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь үндсэн цалинг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Сарын үндсэн цалинг албан тушаал, мэрэгжлийн зэрэглэлийг үндэслэн тогтоож, хоол, үр дүнгийн урамшуулал, илүү цагийн хөлс, шөнө ажилласны нэмэгдэл, удаан жил, бусад гэсэн нэмэгдлүүдийг олгосон байна. 2013 оны шинэчлэгдсэн цалингийн хамгийн багаар тогтоосон зуухны машинистуудын үндсэн цалин нь 240.0 мянган төгрөг бөгөөд дээрхи нэмэгдлүүдийг оруулан тооцоход дундажаар 347.0 мянгаас доошгүй цалин олгож байгаа нь Засгийн газрын 78-р тогтоолоор баталсан цалингийн сүлжээгээр уурын зуухны галчын цалин 337.7-379.1 мянган төгрөгөөр тогтоогдсонтой ойролцоо байна. Мөн Говьсүмбэр аймгийн дулааны газрын машинистын цалин 400,0 мянган төгрөг, Дундговь аймгийн дулааны газрын машинистын цалин 384,0 мянган төгрөгөөр цалинжиж байгаа судалгаа гарсан байна. Байгууллагын удирдлагуудын дундаж цалин 781,3 мянган төгрөг ба нийт ажилчдын дундаж цалин 469,0 мянган төгрөг байна.

Төв Чандмань ДЭХГ-ын үйлдвэрчний эвлэлийн хорооны 2013.01.02-ын өдрийн 01 тоот албан бичгээр 2013 оны бизнес төлөвлөгөөнд уурын зуухны машинистуудын цалинг 50 хувь нэмэгдүүлэхээр санал оруулсан байна. Үүнд: Эрчим хүчний салбарын

ажилчдын цалингийн доод хэмжээ 224.6 мянган төгрөг, иймд 151.8 мянган төгрөгийн цалинтай машинистуудын цалинг 50 хувь нэмэгдүүлэхэд 227.0 мянган төгрөг болж Эрчим хүчний салбарын ажилчдын цалингийн доод хэмжээтэй адил болно гэж тооцжээ. Энэ тоотой бусад ажилчдын цалинг нэмэхээр санал оруулаагүй байхад гүйцэтгэх захирлын 2013.04.26-ны өдрийн 82 тоот тушаалаар бүх ажилчдын цалинг 20 хувь нэмсэн байна.

2013 онд 1147.1 сая төгрөгний цалин олгосноос удирдлагын цалинд 37.5 сая төгрөг, ДЭХ албанд 537.9 сая төгрөг, УСОС албанд 377.2 сая төгрөг, дотоод ажил сургалтын албанд 16.9 сая төгрөг, диспечерийн албанд 75.3 сая төгрөг, СЭЗАлбанд 35.6 сая төгрөг, БОНХ албанд 66.8 сая төгрөгний цалин тус тус олгосон байна. Нийт цалингийн сангийн 46.8 хувийг дулааны ажилчдын цалин эзлэж байна. Мөн нөөцийн сангийн харуул, худгийн моторчин, диспечер, машинист нарт илүү цагийн хөлс буюу шөнийн нэмэгдлийг олгож байна. Хөдөлмөрийн хуулийн 52, 53, 54 дүгээр зүйлд “нийтээр амрах баярын өдөр ажилласны нэмэгдэл хөлсийг 2 дахин, илүү цагийн хөлсийг 1.5 дахин буюу түнээс дээш хэмжээгээр, шөнийн цагаар ажилласан ажилтныг хамтын ба хөдөлмөрийн гэрээгээр зохицуулна.” гэсэн заалтын дагуу халаалтын зуухнуудын ээлжийн ажилчдад илүү цагийн хөлс 1 цагийн тарифыг 2 дахин, шөнийн нэмэгдлийг 1.5 дахин нэмэгдүүлэн бодож олгож байна.

2009 оноос эхлэн байгууллагын захиралын тушаалаар үр дүнгийн урамшуулал олгох журмыг баталж сар бүрийн ажлын үр дүнтэй холбож 20 хүртэл хувиар цалинг нэмэгдүүлэн олгож байна. Энэхүү журмыг өнөөгийн шаардлагад нийцүүлэн өөрчлөх хэрэгтэй байна. Байгууллагын үр дүнгийн урамшуулал олгох журмаа зөрчин тухайн сард сахилгын шийтгэл хүлээсэн зарим нэг хүмүүсийн үр дүнгийн урамшуулал цалинг хасалгүй олгох явдал байгааг хойшид анхаарч ажиллах шаардлагатай байна. Мөн цалингийн товчоо нь зарим суутгалыг орхигдуулан гараар тохируулдаг байсныг аудитын явцад засуулан цалингийн программд суулгуулан суутгалуудыг тулган тохирууллаа.

Аудитын явцад байгууллагын ажилчдын ажил үүргийн хуваарийг судалж үзэхэд аж ахуйн нярав, борлуулалтын техникч, автын механик 1, цахилгааны инженер, тракторын жолооч 1, эдийн засагч, орон сууцны засварчин, орон сууцны инженер, тогооч, чацарганы манаач зэрэг орон тоог оновчтой байдлаар зохицуулснаар бусад ажилчдын ажил үүргийн хуваарьт хариуцуулан цалин, НДШ-ийн зардлыг 63.6 сая төгрөгөөр хэмнэх боломж байна. Борлуулалтын орлого хариуцсан 8 хүн ажиллаж байхад өрөө барагдуулж чадахгүй өр барагдуулагч хөлсөөр ажиллуулж байгаа нь зохисгүй юм.

Иймд байгууллагын албадуудын бүтэц орон тоо тийм ч оновчтой биш байгааг анхаарч ажлын ачааллыг харгалзан хэмнэж болох, хавсран ажиллаж болох орон тоог нягтруулах замаар цалингийн зардлыг хэмнэх шаардлагатай.

Байгууллагын хамтын гэрээнд заасны дагуу 2009-2012 онд өндөр насны тэтгэвэрт гарсан 9 хүнд 28.3 сая төгрөгийн тэтгэмж олгохоор Төв Чандмань ДЭХГ-ын захирлын 2012.10.30-ны өдрийн 168 тоот тушаал гарсанаас 7 хүн нь одоо ажиллаж байна. Тэтгэмжийг бүрэн олгоогүйгээс өглөг 17.2 сая төгрөгөөр өссөн байна.

1.3. Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл нь эрх үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байна уу?

Төлөөлөн удирдах зөвлөл эрх үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, хяналтын зөвлөл огт ажиллаагүй байна.

2009-2012 оны хооронд аймгийн ИТХурлын Тэргүүлэгчид ТУЗ-ийн үүрэг гүйцэтгэж байсан байна. 2012 оны сүүлчээс ТУЗ томилогдон 2013.01.11-ны өдөр хуралдаж 02 тоот тогтоол гарган Төв Чандмань ДЭХГ-ын 2013 оны орлого зарлагын төлөвлөгөөг баталснаас өөр үйл ажиллагаа явуулаагүй байна. Энэ нь Компаний тухай хуулийн 80.1-д “ТУЗөвлөл сард нэг удаа хуралдана, шаардлагатай гэж үзвэл нэмэлтээр хурал хийж болно” гэсэн заалтыг зөрчиж байна. Тус хуралдаанаар байгууллагын орлогыг 3113.9 сая төгрөгөөр, зардлыг 3779.0 сая төгрөгөөр, нийт 665.1 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөгөөг баталжээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 111 тоот тогтоолоор “Төв Чандмань ДЭХГ” ОНӨҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөлийг шинэчлэн байгуулсан байна. Энэ тогтоолоор ТУЗ-д холбогдох хууль тогтоомжид заасан эрх, үүргийг хэрэгжүүлж, “Төв Чандмань ДЭХГ-ын үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг даалгасан байна. Шинээр байгуулагдсан ТУЗ нь байгууллагын хүндрэлтэй асуудлууд болон алдагдалгүй ажиллуулах зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэж ажиллах шаардлагатай байна.

1.4 Техник технологийн шинэчлэлтийн ажил үр дүнтэй хэрэгжсэн үү?

Техник технологийн шинэчлэл хийснээр 1мЗ-д зарцуулагдах нүүрсний хэмжээ буурчээ.

ДЭХАлбанд 2012, 2013 онуудад хөрөнгө оруулалтаар 1225.3 сая төгрөгийн техникийн шинэчлэл хийгдсэн байна. Үүнд: Халаалтын 2, 3, 4-р зуухны барилгын өргөтгөл, зуух тоног төхөөрөмжийн шинэчлэл засварын ажил, зуухны сүлжээний усны насосыг шинэчилж, ус зөөлрүүлэх төхөөрөмжийг суурилуулжээ. 3-р зуухны шинэчлэлд 553.6 сая төгрөг, 2, 4 дүгээр зуухны шинэчлэлд 631.7 сая төгрөгийн ажлыг нээлттэй тендер шалгаруулалтаар Төв Чандмань ДЭХГ хийж гүйцэтгэжээ. Дээрхи зуухнуудыг шинэчилснээр ажлын байрны ажиллах орчин сайжирч, хөдөлмөр хөнгөвчилсөн, хөдөө орон нутгийн дулаан үйлдвэрлэлд механикжсан технологи мөн утааны хийтэй хамт хаягдаж байгаа хүлэмжийн хийн агууламжийг бууруулсан шинэ технологи нэвтрүүлжээ.



УСОС алба нь 2012 онд 150.0 сая төгрөгийн, 2013 онд 224.0 сая төгрөгийн нийт 374.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл, засвар үйлчилгээ болон техник, технологийн шинэчлэлийн ажлыг улс болон орон нутгийн хөрөнгө оруулалт, аж ахуйн нэгж байгууллагын эх үүсвэрээр хийжээ. Эдгээр ажлуудыг хийж гүйцэтгэхдээ 2012 онд 3, 2013 онд 5 нийт 8 ажлын 3 нь нээлттэй тендерээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажил гүйцэтгүүлснээс Төв аймгийн Зуунмод хотын зөөврийн 5 усан сангийн барилга тоног төхөөрөмжийн шинэчлэлийн ажил 45.5 сая, орон сууцны 9 байрны гадна шугамуудын засвар 94.5 сая төгрөгийн өртөгтэй хөрөнгө оруулалтын ажлыг Чандмань ДЭХГазар шалгарч гүйцэтгэсэн байна. /Хавсралт1/

Давтамж хувиргах төхөөрөмж ашигласнаар хувьсах зарцуулалттай цахилгаан бага зарцуулах боломжтой орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлсэн, сүлжээний нэмэлт усыг зөөлрүүлэн халаалтын тогоонд ашигласнаар тогооны халах гадаргууг бохирдол, зэврэлт, хаг хусам тогтохоос хамгаалах шинэ техник, технологийг нэвтрүүлэн шинэчлэл хийсэн байна.

Мөн прокурорын байгууллагын 15.4 сая төгрөгийн шугамын шинэчлэлийн ажлыг тухайн байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгэжээ.

2013 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3-р зуухны халаалтын тогоо, тоног төхөөрөмжийн технологийн шинэчлэлийн 569.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг нээлттэй тендер шалгаруулалтаар 553.6 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулж гүйцэтгэсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 4.1-т “дараахь этгээд захиалагч байна. Үүнд: 1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 5.1.6-д “тендерт оролцогч” гэж захиалагчаас хараат бус дараахь этгээдийг ойлгоно. Үүнд: 1. Дангаараа тендер ирүүлсэн этгээд: 2. Хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг тендер ирүүлсэн хэд хэдэн этгээд, Сангийн сайдын 2006 оны 418-р тушаалаар баталсан “Бараа нийлүүлэх тендерийн жишиг баримт бичиг”-ийн /ТБОНӨХБАҮХА/ тухай хуулийн 19.1, 52.1.3 дахь заалт/ 4.2-т “Дараахь тохиолдолд тендерт оролцогчийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд: 4.2.3-т “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг, 4.2.5-д “тендерт оролцогч нь бараа ажил, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой” гэсэн заалтууд зөрчигджээ.



Орон нутгийн хөрөнгө оруулалтаар байгаль орчинд ээлтэй Герман улсын шинэ технологи болох 50 хүний ахуйн хэрэглээний бохир усыг цэвэршүүлэх байгууламжийг Архуст сумын хүн эмнэлэг болон Зуунмод хотын жишиг хороололд барих тус бүр 63.0 сая төгрөгийн өртөгтэй ажлыг Төв Чандмань ДЭХГ нь хийж байна.

Дээрхи техник, технологийн ажлуудыг хийснээр дулаан цэвэр, усны шугам шинэчлэгдэх, гэр хорооллын иргэдийг цэвэршүүлсэн усаар хангаж, ахуйн хэрэглээний бохир усыг цэвэршүүлэн байгаль орчинд ээлтэй шинэ технологи нэвтрүүлэх боломжтой болно. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бохир соруулах, бохирын шугам сүлжээ угаах, бохирын худаг, шугамын бөглөрөл гаргах тусгай зориулалтын 76.8 сая төгрөгийн өртөгтэй автомашиныг өгсөн бөгөөд уг машиныг ашигласнаар ариутгах татуургын шугам сүлжээ, ариутгах татуургын худаг, цэвэрлэх байгууламжийн бохирын цооног цэвэрлэгээ үйлчилгээг богино хугацаанд чанартай хийж гүйцэтгэх, ажил үйлчилгээг хөнгөвчлөх нөхцөл бүрджээ.

Мөн зуухнуудын техник, технологийн шинэчлэл хийгдэхээс өмнө 8 халаалтын хэсэгт 611.9 мянган м³ талбайг халаах хүчин чадалтай байсан бол одоо 7 халаалтын хэсэгт 637.6 мянган м³ эзэлхүүнтэй талбайг халаах хүчин чадалтай болжээ.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2, 3, 4-р халаалтын зуухнуудын тоног төхөөрөмжинд 1185.3 сая төгрөгийн технологийн шинэчлэл хийснээр зуухны дулаан үйлдвэрлэх техникийн хүчин чадал нэмэгдэж, хөдөлмөрийн бүтээмж, ажиллах нөхцөл сайжирчээ. Мөн халаах талбайн хэмжээ 25.7 мянган м³-ээр нэмэгдэн, 1м³ талбайг халаах нүүрсний хэмжээ 1.8 кг-аар буурсан боловч нүүрсний үнэ нэмэгдснээс 1м³ талбайг халаах зардал буураагүй байна.

Бүлэг 2

ТУЗ алдагдалтай ажиллах төлөвлөгөө баталснаас ОНӨҮГ нь батлагдсан төлөвлөгөөний дагуу ашиггүй ажиллаж байна.

2.1. ОНӨҮГазрыг үр ашигтай тогтвортой ажиллуулах зорилгоор борлуулалтын орлого, үйл ажиллагааны зардал, ашиг алдагдлыг бодитой тооцож төлөвлөсөн байна уу?

Алдагдалтай ажиллах төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажилласан байна.

2013.01.11-ны өдөр удирдах зөвлөл хуралдаж 02 тоот тогтоолоор Төв Чандмань ДЭХГ-ын 2013 оны орлогыг 3113.9 сая төгрөгөөр, зардлыг 3779.0 сая төгрөгөөр буюу нийт 665.1 сая төгрөгийн алдагдалтай ажиллах төлөвлөгөөг баталсан байна. Уг тогтоолд 1-рт Хэрэглэгчдийг хямд өртөгтэй чанартай дулаанаар хангах нэгж бүтээгдэхүүний өртөг зардлыг хямдруулахын тулд шинэ техник технологийг нэвтрүүлэх, техник зохион байгуулалтын арга хэмжээ авах, 2-рт Үндсэн хөрөнгийн элэгдлийг орон нутгийн хөрөнгө оруулалтаар тодорхой хэмжээгээр шийдвэрлэж байх тул элэгдлийн хэмжээг нормативаас багаар тооцох, 3-рт ОНӨҮГазрыг алдагдалгүй ажиллуулах, хэрэглэгчдийг найдвартай чанартай дулаан, усаар хангахын тулд Эрчим хүчний зохицуулах зөвлөлд хандаж дулааны үнэ тарифыг нэмж батлуулах арга хэмжээ авах гэсэн байна.

Энэ тогтоол нь нэгдүгээр заалтаараа хямд өртөгтэй дулаанаар хангах, гуравдугаар заалтаараа үнэ тарифыг нэмэх гэсэн нь нэг нь нөгөөгөө үгүйсгэсэн агуулгатай шийдвэр болжээ.

“Төв Чандмань ДЭХГ” ОНӨҮГ-ын дүрмийн захирлын эрх, үүрэг хэсэгт “Компаний санхүүгийн тогтвортой байдлыг хангаж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж өртөг зардлыг багасгах, ашиг орлогыг нэмэгдүүлэх” гэсэн заалт зөрчигдөн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь зардал хэмнэх зарчим, боломжийг нарийвчлан судалж дүгнэлт хийлгүйгээр байгууллагын орлого зарлагын төлөвлөгөөг алдагдалтай байхаар баталж байгаа нь Компаний тухай хуулийн 76 дугаар зүйл, ОНӨҮГазрын Удирдах зөвлөлд төлөөлөл хэрэгжүүлэх журмын 2.8, 3.5 дахь заалт, ОНӨҮГазрын дүрмийн 7-р зүйл заалтыг тус тус зөрчжээ. /Хавсралт2/


2014 оны төлөвлөгөөгөөр 4197.1 сая төгрөгийн орлого, 4422.8 сая төгрөгийн зардалтай, алдагдал нөхөх санхүүжилтэнд 102.0 сая төгрөг авч 123.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллах төлөвлөгөөг ТУЗ-аас батласан нь өмнөх оны гүйцэтгэлээс орлого 723.7 сая төгрөгөөр, зардал 853,9 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна.

2.2. Борлуулалтын орлогыг бүрэн бүрдүүлж байна уу?

Борлуулалтын орлогыг бүрэн тооцсон байна.

Батлагдсан орлогын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллахын тулд сар, улирлаар хуваарилан, төлөвлөгөөний биелэлтийг захирлын зөвлөлд сар бүр хэлэлцүүлэн ажиллаж иржээ.

2013 онд нийт 8 зуух ажиллуулж 43 төсөвт байгууллагын 215505.9 м3 талбай, 143 ААНБ-ын 41987 м3 талбай, 1554 айл өрхийн 184643.7 м3 эзэлхүүнтэй талбайг халааж нийт 3094.5 сая төгрөгийн орлого оруулсан байна. Шалгалтын явцад бүх төсөвт болон ААНБ-ын талбайн эзэлхүүн, түүнээс орох орлогын хэмжээг тооцож үзэхэд борлуулалтын орлогыг бүрэн тооцсон байна.



Айл өрх нь нийт халаалтын талбайн 42 хувийг эзлэж байгаа боловч орлогын дөнгөж 6 хувийг бүрдүүлж байна.

Төв Чандмань ДЭХГ нь 2012 онд үйл ажиллагааны 121,0 сая төгрөгийн, нийт 27.9 сая төгрөгийн алдагдалтай, 2013 онд үйл ажиллагааны 6,5 сая төгрөгийн ашигтай, нийт 25,7 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. 2012 онд ДЭХА нь ашигтай ажиллаж уг ашгаараа НБЗГ, УСОС албадын алдагдлыг нөхөж ажилласан байна. /Хавсралт3 дэлгэрэнгүй/

2013 оны ашиг, алдагдлын тооцоо					
	Салбар нэгж	ББӨртөг	Борлуулалтын орлого	Эзлэх хувь	Ашиг алдагдал
1	Дулаан	3016427.3	3099102.4	89.2	82675.1
2	Цэвэр ус	276273.6	178967.7	5.2	-97305.9
3	Сувагжуулалт	141828	119102.5	3.4	-22725.5
4	Усан сан	71476.5	14130.3	0.4	-57346.2
5	Орон сууц	60564	60564	1.7	0
6	Нийтийн бие засах газар	16714.4	1555.2	0.04	-15159.2
7	Удирдлагын зардал	47119.4	0	0.0	-47119.4
	Бүгд	3630403.2	3473422.1	100	-156981.1

УСОС алба нь 2013 онд нийт 485.6 мянган м3 ус олборлож 208 мянган м3 усны алдагдалтай, нийт 223.2 мянган м3 цэвэр ус борлуулсны 72.1 мянган м3 усыг

1900 төгрөгөөр ААНБайгууллага болон төсвийн байгууллагуудад борлуулж 137.0 сая төгрөг, айл өрхийн 2780 хүнд 1200 төгрөгөөр борлуулж 40.0 сая төгрөг, гэр хороололын усан сангаар 10.3 мянган м3 усыг 14.1 сая төгрөгөөр, айл өрхийн усны тоолууртай хэрэглээгээр 6.5 мянган м3 усыг 1м3-ыг 0.3 төгрөгөөр борлуулж 1.9 сая төгрөг буюу цэвэр усны борлуулалтаас нийт 193.0 сая төгрөгийн орлого оруулсан байна. Мөн сувагжуулалтаар 64.7 мянган м3 бохир усыг зайлуулж 119.1 сая төгрөгийн орлогыг оруулж уг алба нь нийт 312.1 сая төгрөг, нийтийн бие засах газар нь 1.6 сая төгрөгийн орлого оруулжээ.

2012 оны Төв Чандмань ДЭХГ-ын удирдах зөвлөлийн хуралдааны 01 тоот тогтоолоор “СӨХ-ны үйл ажиллагааг алдагдуулахгүй ажиллуулах, хуулийн хүрээнд үйл ажиллагааг явуулах” үүрэг өгөгдсний дагуу Төв Чандмань ДЭХГ-ын гүйцэтгэх захирлын 2013 оны 01 сарын 18-ны өдрийн “Үнэ шинэчлэн тогтоох тухай” 14 тоот тушаалаар “СӨХ-д шилжсэн орон сууцанд амьдардаг айл өрхийн үйлчилгээний хөлсийг 1м2 талбайгаас 206 төгрөг /НӨАТ-гүй/ болгон нэмэгдүүлэн 2013.01.01-ний өдрөөс эхлэн тооцох болсны дагуу СӨХ нь 2013 оноос ашиг, алдагдалгүй ажилласан байна.

2013 онд үндсэн ажил, үйлчилгээний борлуулалтаас 3114.0 сая төгрөгийн орлого орохоос 3473.4 сая төгрөгийн орлого оруулж, орлогын төлөвлөгөөг 359.4 сая төгрөгөөр буюу 111,5 хувиар давуулан биелүүлжээ. Нийт борлуулалтын орлогын 89.2 хувийг ДЭХА-наас, 9 хувийг УСОСА-наас, 1.8 хувийг СӨХ-оос оруулсан байна.

2.3 Үнэ тарифыг үндэслэлтэй тогтоож, батлаж өгсөн байна уу?

Үнэ тарифыг өөрчлөхдөө холбогдох тооцоо судалгааг хангалтгүй хийснээс зохицуулах зөвлөлийн тогтоол шийдвэр хэрэгжихгүй байна.

Төв Чандмань ДЭХГазар нь үнээ тогтоохдоо “Эрчим хүчний тухай” хуулийн 26.2.2-т “цахилгаан, дулааны хангалтад хэрэглэгчдээс тавих шаардлагатай уялдуулан хэрэглэгчийн ангилал тус бүрээр өртөг, зардлыг хуваарилах”, 27.6-д “Тариф болон гэрээний үнэ нь эрчим хүчний хангамжийн үзүүлэлт болон бусад хүчин зүйлээс хамааран тодорхой бүлэг хэрэглэгчийн хувьд ялгаатай байж болно” гэж заасны дагуу үнэ, тарифыг ААНБ, төсөвт байгууллага, айл өрх гэсэн 3 ялгаатай үнээр хэрэглэгчдэд 1м3 дулааныг борлуулж байна.

Монгол улсын эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн “Зохицуулах хорооны бүрэн эрх”-ийн 1.4-т “тариф тогтоох аргачлал боловсруулах, тарифын бүтэц тодорхойлох, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифыг хянаж батлах, хэрэглэгчдэд худалдах үнийг тогтоох, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх” бүрэн эрхийг хэрэгжүүлнэ, 26 дугаар зүйлийн “Тариф тогтоох зарчим”-ын 2.1-т “Үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах” гэж заасны дагуу 2012 он, 2013 оны тус газрын бодит өртөг, зардалд тулгуурлан үнэ, тарифыг ЭХЗГ-ын зохицуулагчдын зөвлөлийн 2004 оны “Аргачлал батлах тухай” 63 дугаар тогтоолын дагуу аудитын явцад тооцож үзлээ. /Хавсралт №5/

Төв Чандмань ДЭХГ ОНӨҮГ-ын гүйцэтгэх захирлын 2012 оны “Үнэ өөрчлөх тухай” 150 тоот тушаалаар “Хэрэглээний халуун усны үнийг 1 хүнд 1305 /НӨАТ-гүй/ төгрөгөөр, 2013 оны “Үнэ шинэчлэн тогтоох тухай” 14 тоот тушаалаар СӨХ-нд

шилжсэн орон сууцанд амьдардаг айл өрхийн үйлчилгээний хөлсийг 1м² талбайгаас 206 төгрөгөөр, 2010 оны “Үнэ батлах тухай” 46 тоот тушаалаар 1м³ цэвэр усыг ААНБ болон төсвийн байгууллагад 1900 төгрөгөөр, 1м³ бохир шингэн зайлуулах үнийг 1520 төгрөгөөр тогтоосон байна.

Тус газар нь 1м³ дулааныг төсөвт байгууллагуудын хувьд 2011 оны 8 сард батлагдсан 1450 төгрөгөөр, ААНБ-ын хувьд хэрэглэгчээ алдахгүй, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих аймгийн бодлогын дагуу 2004 оноос эхлэн үнийг тогтмол 650 төгрөгөөр, айл өрхийн хэрэглэгчийн хувьд 2011 оноос 1м² дулааныг 304 төгрөгөөр борлуулж байсан байна. /Хавсралт №4/

Төв Чандмань ДЭХГ-ын удирдах зөвлөлийн 2013 оны 01 сарын 11-ний өдрийн 02 тоот тогтоолоор Төв Чандмань ДЭХГ-ын 2013 оны орлого, зарлагын төлөвлөгөөг 665.1 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар батлаж, уг тогтоолын 2.3-т “ОНӨҮГ-ыг алдагдалгүй ажиллуулах, хэрэглэгчдийг найдвартай чанартай дулаан, усаар хангахын тулд Эрчим хүчний зохицуулах зөвлөлд хандаж дулааны үнэ тарифыг нэмж батлуулах арга хэмжээ авах үүрэг өгөгдсний дагуу Төв аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2013 оны 05 сарын 08-ны өдрийн 02 тоот “Үнэ тариф батлах тухай” тогтоолоор ААНБ-ыг 200 төгрөгөөр нэмэгдүүлж 850 төгрөг, төсөвт байгууллагыг 450 төгрөгөөр нэмэгдүүлж 1900 төгрөг, айл өрхийг 46 төгрөгөөр нэмэгдүүлж 350 төгрөг болгож нэмэгдүүлжээ. Үнийг 2013 оны 09 сарын 15-наас нэмэгдүүлж, 2013 оны сүүлийн хагаст үнийн зөрүүнээс нийт 353.4 сая төгрөг орохоос төсөвт байгууллагаас 327.1 сая төгрөг /НӨАТ-гүй/, ААНБ-аас 26.3 сая төгрөгийн борлуулалтын орлого оруулахаар нэмэгдүүлсэн үнээр борлуулалт хийж нэхэмжилэн тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан боловч зарим сургууль, цэцэрлэгүүдээс төсвийн тодотгол хийгдээгүй гэсэн шалтгаанаар 159.3 сая төгрөг /НӨАТ-тай/ төлөгдөөгүй авлага үүссэн байна. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас зөвшөөрөл авалгүй эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс айл өрхийн дулааны үнийг нэмэх тогтоол гаргасан нь хэрэгжих боломжгүй болж 10.0 сая төгрөгний орлого ороогүй байна.

Төв Чандмань ДЭХГ-ын хувьд 1м³ талбайг халаах бүтээгдэхүүний өөрийн өртөг 830 төгрөг бол өөрийн өртөгөөсөө төсвийн байгууллагуудад 2.3 дахин илүү, айл өрхөд 7.6 дахин бага буюу 2.7м³ талбайн хөлсийг 1м²-аар тооцож 129.6 төгрөгөөр борлуулж байна.


Аймгийн ИТХ-ын 2012.09.19-ны өдрийн 33 тоот хурлын тэмдэглэл, Төв Чандмань ДЭХГ-ын Удирдах зөвлөлийн 2012.07.20-ны өдрийн хуралдааны 01 тоот тогтоолоор “айл өрхийн орон сууцны халаалтын төлбөр тооцох талбайд гал тогоо, ариун цэврийн өрөө, коридорыг оруулж тооцох” үүрэг өгөгдсний дагуу гүйцэтгэх захирлын 2012.12.17 оны 215 тоот тушаал гарч 2013.01.01-ний өдрөөс талбайн хэмжээг нэмэгдүүлэн тооцож байна.

Цэвэр усны хэрэгцээ их болж нөөц багасаж байгаа тул усны үнэ цэнийг өндрөөр үнэлж төсөвт байгууллага, аж ахуй нэгж, орон сууцны айл өрхийн хэрэглээний цэвэр бохир усны нэгжийн үнийг 50-иас доошгүй хувиар нэмэгдүүлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлвэл усны алдагдлыг 150.0 сая төгрөгөөр бууруулах боломж байна.

2.4 Хөрөнгийг арилван хэмнэлттэй зарцуулж байна уу?

Тээвэр, цалингийн зардлыг бууруулж, үр ашиггүй зардлуудыг хэмнэснээр ашигтай ажиллах боломж байна.

2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 3047.9 сая төгрөгийн орлого, 3168.8 сая төгрөгийн зардал, 121.0 сая төгрөгийн алдагдалтай, алдагдал нөхсөн санхүүжилт 51.5 сая төгрөг орж ирснээр 69.5 сая төгрөгийн алдагдал, 242.1 сая төгрөгний дансны авлага, 718.7 сая төгрөгийн өр төлбөртэй ажиллажээ. 2013 оны жилийн эцсийн тайлангаар үндсэн үйл ажиллагаанаас 3473.4 сая төгрөгийн орлого оруулж, 3630.4 сая төгрөгийн зардал гаргаж, 157.0 сая төгрөгийн алдагдалтай, алдагдал нөхсөн санхүүжилт 163.5 сая төгрөг орж ирснээр 6.5 сая төгрөгийн ашиг, 340.4 сая төгрөгийн дансны авлага, 894.9 сая төгрөгийн өр төлбөртэй ажиллаж үйл ажиллагааны санхүүгийн үр дүн өмнөх оноос буурсан байна.



Нийт зардлын бүтцийг авч үзвэл нүүрсний зардал 1274.2 сая төгрөг, цалин, НДШ-ийн зардал 1266.9 сая төгрөг, тээврийн зардал 433.2 сая төгрөг, цахилгааны зардал 253.8 сая төгрөг, удирдлагын зардал 47.1 сая төгрөг, бусад зардал буюу хөдөлмөр хамгаалал, төлбөр хураамж, уралдаан тэмцээн, баяр ёслол, шагнал урамшуулал, тэтгэмжийн зардал 355.1 сая төгрөг байна.

Монгол улсын Засгийн газрын 2012 оны 6 сарын 13-ны өдрийн “Гэр хорооллын усны үйлчилгээний төлбөрийг хөнгөлөх тухай” 209 тоот тогтоолоор “одоо мөрдөгдөж байгаа усны үйлчилгээний төлбөрийг бууруулснаар ус ханган нийлүүлэгч байгууллагад үүсэх алдагдлыг тооцон санхүүгийн эх үүсвэрийг нь шийдвэрлэхийг Сангийн сайдад, цаашид жил бүр орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай”, “Хот, суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл”-ийн 2013 оны 05 сарын 17-ны өдрийн 01/231 албан тоотоор “санхүүгийн хүндрэлд орсон тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагааны орлогоор нөхөх боломжгүй байгаа бодит зардлыг нь орон нутгийн төсвийн хөрөнгөнөөс татаас хэлбэрээр олгуулах тухай”, Төв Чандмань ДЭХГ-аас “...алдагдал нөхөхөд зориулж 208.8 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж өгөх” тухай хүсэлтийг аймгийн удирдлагад тавьсан байна. Уг 208.8 сая төгрөг нь УСОС-ны албаны нийт алдагдлыг ХБГ-ээр тооцож гаргасан тооцоо бөгөөд 2013 оны жилийн эцсийн байдлаар УСОСА нь 192.5 сая төгрөгийн алдагдалтай гарч аймгийн ИТХ-ын 2013 оны 12 сарын 03-ны өдрийн 6 дугаар хуралдааны 01 тоот “2013 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор тус газрын ус сувгийн зардалд 213,4 сая төгрөг батлагдаж, үүнээс 2013 оны алдагдал нөхөхөд 163.5 сая төгрөг, өмнөх оны алдагдал нөхөхөд 49.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Аймгийн ИТХТ-ийн 2006 оны 101 тоот тогтоолын 2-т “Нийтийн бие засах газрын эд хөрөнгийг актаар хүлээлцүүлж, ажиллуулах зардлыг жил жилийн төсөвтөө тусган санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргад даалгасугай”, Төв Чандмань ДЭХГ-ын удирдах зөвлөлийн 2012 оны 01 тоот тогтоолын 1.2-т “Нийтийн бие засах газрын зардлыг санхүүжүүлэх асуудлыг аймгийн ЗДТГ-ын санхүү төрийн сангийн хэлтэст хандаж шийдвэрлүүлэх” үүрэг өгөгдсөн боловч өнөөдрийг хүртэл хэрэгжээгүй байна. 2013 онд нийтийн бие засах газар нь 2 хүний орон тоотойгоор 16.7 сая төгрөгийн зардал гаргаж, 1.6 сая төгрөгийн орлого оруулж, 15.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь тухайн компаний үйл ажиллагааны алдагдалд нөлөөлж байгаа тул цаашид энэ асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

Төв Чандмань ДЭХГазар нь 2012, 2013 онуудад ТБОНӨХБАҮХАТухай хуулийн дагуу 3 зуухны шинэчлэл, шугамын засварын нийт 1325.3 сая төгрөгийн 4 худалдан авах ажиллагаанд оролцож, гадны байгууллагын ариутгах татуургын шугамын засварын 15.2 сая төгрөгийн ажлыг гэрээгээр, Зуунмод, Архуст сумдад 50 хүний ахуйн бохир цэвэрлэх байгууламж барих 126.0 сая төгрөгийн бүгд 1599.1 сая төгрөгийн ажлуудыг гүйцэтгэж 60.0 сая төгрөгийн цалин, 15.7 сая төгрөгийн төлөвлөгөөт хуримтлал, нийт 75.7 сая төгрөгийн цалин, төлөвлөгөөт хуримтлалыг ажлын гүйцэтгэлээр гаргаж 2012 онд 4 дүгээр зуухнаас 45.2 сая төгрөг, 2013 онд 2 дугаар зуухнаас 6.9 сая төгрөг, 3 дугаар зуухнаас 6.3 сая төгрөг, прокурорын засварын ажлаас 1.1 сая төгрөг, нийт 59.5 сая төгрөгийн ашгийг үндсэн үйл ажиллагааны бус орлогод бүртгэж тайлагнажээ.

2013 онд улсын хөрөнгө оруулалтаар 2, 4 дүгээр зууханд 631.7 сая төгрөг зарцуулсан бөгөөд үүнээс 120.7 сая төгрөг нь барилга, 3 дугаар зууханд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 553.6 сая төгрөг зарцуулсан бөгөөд үүнээс 130.6 сая төгрөг нь барилгын зуухны шинэчлэлийн ажил хийгджээ. Зуухнуудын техник, технологийн шинэчлэл хийгдснээр 7 халаалтын хэсэгт 637.6 мянган м3 буюу өмнөхөөс 25.7 мянган м3 эзэлхүүнтэй талбайг нэмж халаах хүчин чадалтай болж, ажлын байрны ажиллах орчин сайжирч, хөдөлмөр хөнгөвчилсөн, механикжсан боловч нүүрсний зарцуулалт өмнөхөөсөө 2 дугаар зуух 1251.9 тонноор буурсан, 3 дугаар зуух 627 тонноор нэмэгдсэн, 4 дүгээр зуух 515.7 тонноор нэмэгджээ. 2013 онд өмнөх оноос хэрэглэгчийн тоо 128-аар, талбайн хэмжээ 56.3 мянган м3-ээр нэмэгдсэн боловч 92.2 хувь нь буюу 118 нь айл өрх, үлдсэн 9 хэрэглэгч буюу 7.8 хувь нь ААНБ бөгөөд нүүрсний зарцуулалт 625 тонноор нэмэгджээ.

Төв Чандмань ДЭХГ нь 2012 онд 47749.7 тн нүүрсийг 1093.6 сая төгрөгөөр, 2013 онд 48374.2 тн нүүрсийг 1274.2 сая төгрөгөөр худалдан авч хэрэглэжээ. 2013 оны нийт зардлын 35 хувийг нүүрсний зардал, 12 хувийг тээврийн хөлсний зардал эзэлж байна. 2013 онд нүүрс нийлүүлэх, тээвэрлэх тендерийг зарлаж, нүүрс тээвэрлэх “Ингүүмэл мандал” ХХК 1 тн.км-ийн тээврийн хөлсийг 190 төгрөгөөр, нүүрс нийлүүлэхэд “Ар баянгол” ХХК 6000 тонн нүүрсийг 1 тонныг нь тээврийн хөлсийг оролцуулан 34000 /НӨАТ-гүй/ төгрөгөөр нийлүүлэх саналаа ирүүлснийг үнэлгээний хорооны хурлаар хэлэлцэн 2 компанийг хоёуланг шалгаруулжээ. Тус байгууллага нь нүүрс нийлүүлэх, тээвэрлэх тендерийг “ТБОНӨХБАҮХАТухай хууль”-ийн дагуу олон нийтийн хэвлэл, мэдээлэлийн хэрэгслээр зарлан явуулдаг боловч бодит хэрэглээнээс бага хэмжээтэй худалдан авалтанд тендер зарладагаас оролцогч цөөн, өрсөлдөөн байдаггүй байна. Энэ нь “ТБОНӨХБАҮХАТухай хууль”-ийн 6.1-т “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлана”, 8.2-т “энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт

өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 8.4-т “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа ажил үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно” гэсэн заалтууд зөрчигджээ.

2013 онд хэрэглэсэн нийт нүүрсний 12.6 хувийг Шивээ овоо ХХК-с, 27.4 хувийг Ар баянгол ХХК-с, 41.8 хувийг Петрокоайл ХХК-с, 18.2 хувийг Багануур илч ХХК, Багануур ХК-с, Багануур сувилал ХХК, Налайх дөл ХХК-с худалдан авч, нүүрсний тээврийн зардалд 433.2 сая төгрөг зарцуулсан байна.

1 тонн нүүрс нь дундажаар 2012 онд 22900 төгрөг, 2013 онд 24879 төгрөгийн үнэтэй, вагоноор тээвэрлэх, ачих, буулгах зардал дундажаар 9909 төгрөг, автомашинаар нүүрс тээвэрлэх зардал $47\text{км} \times 190 = 8930$ төгрөгийн зардалтайгаар нийлүүлэгджээ. Нэг тн нүүрсний үнэ судалгаагаар жил тутам 3000 төгрөгөөр өссөн байна.

Багануур ХК-ий ТУЗ-ийн 2013 оны 08 сарын 08-ны өдрийн 02 тоот тогтоолоор нүүрсний үнийг 30%-иар нэмэгдүүлж 32500 төгрөг, “Шивээ овоо” ХК-ий ТУЗ-ийн 2013 оны 08 сарын 15-ны өдрийн 20 тоот тогтоолоор 18600 төг \төмөр замын ачиж буулгах, тээвэрлэх хөлс дундажаар 9909 төгрөг, тээврийн хөлс 8930 төгрөг, бүгд 18839 төгрөг орж тооцогдоогүй үнэ/, “Багануур илч” ХХК-ий гүйцэтгэх захирлын 2013 оны 09 сарын 20-ны өдрийн 58 тоот тушаалаар нүүрсний үнийг 43000 төгрөгөөр борлуулахаар шийдвэр гарсан байна. /Хавсралт7/

2013 онд 7-8 халаалтын хэсэгт 63504.2 мян.гкал дулааныг 48500 тонн нүүрсээр үйлдвэрлэжээ. Нүүрсний зарцуулалт нь хоногийн дулааны ачааллаас шалтгаалан өдөрт зарцуулах нүүрсний хэмжээ янз бүр байдаг байна. 2012-2013 онуудад халаалтын хэсгүүдэд техникийн шинэчлэл, засвар үйлчилгээ хийгдэж одоо ашиглагдаж байгаа техник, тоног төхөөрөмжүүдийг ашиглан халаалтын хэсгүүдийн дулаан үйлдэрлэх хүчин чадал өмнөх оноос 25712,6 м3-ээр нэмэгдэж, нүүрсний зарцуулалтын хэмжээ мөн адил 1098 тонн нүүрсээр нэмэгджээ./Хавсралт6/

Монгол улсын Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2008 оны 09 сарын 08-ны өдрийн 136 тоот “Авто тээврийн жишиг тариф батлах тухай” тушаалаар 267.66 төгрөг байна.

2011-2014 оны тээврийн зардлын судалгаа

Үзүүлэлт	х/нэгж	2011 он	2012 он	2013 он	2014 он
Тээврийн зардал	мян. Төг	314432.3	389098.7	433178	465958
1 тн/км-ын хөлс	төгрөг	155-175	175-187	187-190	190-200
1 тн/км-ын улсын дундаж тариф	төгрөг	267	267	267	267

2009 онд аймгийн Аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудитаас өөрийн тээврийн хэрэгсэлтэй болох талаар тооцоо судалгаа хийж зөвлөмж өгсөн, мөн түүнчлэн 2010, 2011 онуудад аймгийн ИТХурлаас томилсон ажлын хэсэг энэ асуудлыг хөндөж байсан боловч тус компанийг өөрийн тээвэртэй болгох талаар ямар нэгэн тодорхой шийдвэр гараагүй байна.

Одоогоор тус газрын ерөнхий нягтлан бодогчийн гэр бүлийн хүний компани болох Ингүмэлмандал ХХК-аар тээвэр хийлгэдэг байна. Ингүмэлмандал ХХК нь өөрийн балансад 1 тээврийн хэрэгсэлтэй бөгөөд хувь хүмүүсийн тээврийн хэрэгсэлийг дамжуулан ажиллуулдаг, энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн

ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг зөрчсөн байна.

2013 онд 1274.2 сая төгрөгийн 48374.2 тонн нүүрсийг 433.2 сая төгрөг тээврийн зардал зарцуулж тээвэрлэсэн байна. Үүнээс Шивээ овоо ХК-аас 6.0 мянган тонн, Багануур ХХК-аас 0.8 мянган тонн, Багануур илч ХХК-аас 4.4 мянган тонн, бүгд 11.2 мянган тонн нүүрсийг өөрсдөө буюу тээврийн үйлчилгээ үзүүлдэг ААНБ-аар гүйцэтгүүлж 98.4 сая төгрөг зарцуулжээ. Нэг машин 1 удаагийн явалтаар дундажаар 17 тонн нүүрс тээвэрлэдэг гэж тооцвол нэг удаагийн нүүрс тээвэрлэлтэнд $200\text{төг} \times 47\text{км} \times 17\text{тонн} = 159800$ төг болж байна. Дэд бүтцийн сайдын 2004 оны “Жишиг норм батлах тухай” 19 дүгээр тушаалаар ачааны камаз маркын автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг 34-40л, “автомашины 100тн/км тээврийн ажлын болон өөрөө буулгагч автомашины ачаагаа буулгахад зарцуулах шатахууны норм”-ыг 6-20 тн хүртэл даацтай өөрөө буулгагч автомашины ачаатай явалт тутамд 0.5л шатахуун тус тус олгоно гэж заажээ. Үүний дагуу нэг машин 100км-т 40л бензин, ачааны км тутам 0.5л бензин $47\text{км} \times 0.5\text{л} + 40\text{л} = 63.5\text{л} \times 1750\text{төг} = 111125$ төгрөгийн бензин зарцуулагдаж нэг удаагийн явалтаас 48675 төгрөгийн зөрүү гарч байна. Жилдээ тонн нүүрсийг нэг удаагийн явалтаар доод тал нь 17тн-оор зөөвөрлөхөд 659 удаагийн рейсээр зөөвөрлөж жилдээ 32,1 сая төгрөгийн тээврийн зардлын зөрүү гарч байна. /Сардаа 82.4, өдөртөө 4 удаа тээвэрлэх/

Хэрвээ өөрийн байгууллагын 2 машинаар тээвэр хийвэл өдөрт нэг машин 2 удаагийн рейс хийж, жолоочийг 600.0 мянган төгрөгөөр цалинжуулахад жилдээ 14,4 сая төгрөгийн цалин /12 сараар/, НДШ-д 1.7 сая төгрөг, шатахууны зардалд 73.2 сая төгрөг, нийт 89.3 сая төгрөг зарцуулж, тээврийн зардлаас жилдээ 16,0 сая төгрөг хэмнэх боломжтой. Зах зээлийн судалгаагаар /Xacleasing-тэй хамтран ажилладаг 3 компаниас авсан судалгаагаар 25 тоннын даацтай өөрөө буулгагч шинэ 2 машин авахад /100,0-110,0 сая төгрөг/ 200.0 сая төгрөг байна.

Мөн тус газрын УСОС –ны алба нь 2013 онд 242.7 мян.м3 усны алдагдалтай ажилласан бөгөөд аж ахуйн нэгж, төсөвт байгууллага, орон сууцны айл өрхийн хэрэглэх цэвэр, бохир усны өнөөгийн мөрдөж байгаа нэгжийн үнийг нэмэгдүүлэх, тоолууржуулах асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх замаар цэвэр усны алдагдлыг бууруулах боломжтой юм./хавсралт 9/

Тус газрын хувьд тээвэр, цалингийн зардлыг бууруулах боломжтой бөгөөд зар сурталчилгааны зардал, зочид хүлээж авах зардал, уралдаан тэмцээний зардал, баяр ёслол хүлээн авалт, сургалт семинар, тэтгэмжийн зардал гэсэн үргүй зардлуудыг багасгах шаардлагатай байна.

Үйл ажиллагааны бус орлогод нийт 2012 онд 352.1 сая төгрөг орж, 310.4 сая төгрөгийг зарцуулж 41.6 сая төгрөгийн ашиг, 2013 онд 526.0 сая төгрөг орж, 507.2 сая төгрөг зарцуулж 18.8 сая төгрөгийн ашиг гаргасан боловч акталсан хөрөнгийн элэгдэл 51.0 сая төгрөгийн алдагдлыг хасч тайлангаар 32.2 сая төгрөгийн алдагдалтай гаргасан байна.

Үйл ажиллагааны бус орлого зарлагын хувьд 2, 3-р зуухны шинэчлэлийн болон бусад гэрээгээр гүйцэтгэсэн ажлаас /493.3-477.6/ 15.7 сая төгрөгийн ашиг олж,

зарим ажил үйлчилгээ болох харилцах дансны үлдэгдлийн хүү, барилгын компаниудын гүйцэтгэсэн ажил, техникийн нөхцөл олгосны болон бусад үйл ажиллагаа зэргээс орлого оруулж цайны газар /5.7-7.3/ 1.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж бусад зардал аваар ослын үеийн хоолны зардал, НААҮйлчилгээний, шинэ жилийн арга хэмжээний, халаалтын зуухнуудын дундах уралдаан тэмцээний, гадаад сургалтын зардал, сурын холбоонд хандив, НББ-ын бодлогын баримт боловсруулах, спорт заалны түрээс зэрэгт зардал гаргаж нийт /526.0-507.2/ 18.8 сая төгрөгийн ашигтай гарсан нь 2, 3-р зуухны технологийн шинэчлэлийн тендерийн ажлыг өөрийн байгууллагаар хийж гүйцэтгэсэнтэй холбоотой байна.

ДЭХГ нь төрийн сан, ХААН, ХАС, Төрийн банкаар орлого зарлагын гүйлгээ хийлгэж байгаа бөгөөд үүнийг 2009 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар төрийн сангаар зардлын гүйлгээг, арилжааны банкаар орлогын гүйлгээг хийхээр зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүй байна.

Аудитын явцад Төв Чандмань ДЭХГ нь НББ-ийн бодлого хийлгэхээр 5000,0 сая төгрөгний гэрээ хийн 2500,0 мянган төгрөг Бодь Тусгал аудит ХХК-д шилжүүлсэн боловч одоог хүртэл НББ-ийн бодлого нь хийгдээгүй, компани дээр ирж ажилласан судалгаа, шинжилгээний баримт материал байхгүй байгаа нь тухайн аудитын компани ДЭХГ-ын онцлогийг тусгасан баримт бичиг боловсруулах боломжгүй гэж үзэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.1-д “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулах” гэсэн заалтыг зөрчиж байна. Мөн байгууллага нь сурын холбоонд 300,0 мянган төгрөг, аймгийн ганданд 33,9 мянган төгрөгний хандив өгч үргүй зардал гаргасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30.3-д “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно.”, Төсвийн тухай хуулийн 25.10-д “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчиж байгаа тул төлбөрийн акт бичлээ.

2.5 Борлуулсан бүтээгдэхүүний өртгийг зөв тооцоолсон уу?

Борлуулсан бүтээгдэхүүний өртгийг тооцохдоо удирдлагын зардал болон борлуулалтын зардлыг оруулан өртгийг тооцсон байна.

Төв Чандмань ДЭХГ-ын өөрсдийнх нь тооцож гаргасан 1м³ талбайг халаах өртөгөөс 2012 онд мөрдөж байсан борлуулалтын дундаж үнэ нь 58 төгрөгөөр бага байна. Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2013 оны 02 тоот тогтоолоор нэмэгдүүлсэн үнэ нь ААНБ-д бодит өртөгөөрөө, айл өрхөд 7.6 дахин бага үнээр, төсвийн байгууллагад 2,3 дахин илүү үнээр борлогдож байгаа нь айл өрхийн дулааны үнийн алдагдлыг төсвийн байгууллагад борлогдож байгаа үнээр нөхөж байгаа байдал харагдаж байна. 2013 онд бүтээгдэхүүн борлуулах дундаж үнэ нь өмнөх онтой харьцуулахад бүтээгдэхүүний өөрийн өртөгөөс өссөнөөр дулаан хангамжаас олох борлуулалтын орлого нэмэгдэж байна.

2012 онд 84.8 сая төгрөгийн, 2013 онд 90.9 сая төгрөгийн удирдлагын болон бусад зардлыг оруулж тооцсноор нэг м³-д ногдох дулаан эрчим хүч үйлдвэрлэлийн

борлуулсан бүтээгдэхүүний нэгжийн дундаж өртгийг 2012 онд 14 төгрөгөөр, 2013 онд 26 төгрөгөөр илүү тооцсон байна. /Хавсралт8/

УСОСА-ны цэвэр усны өртөг 1208 төгрөг, борлогдож буй үнэ нь 1900 төг, зайлуулсан бохир усны өртөг 789 төгрөг, борлогдож буй үнэ 1520 төгрөг, усан сангийн 1тн усны өртөг 6939 төгрөг, борлогдож буй үнэ 1363 төгрөг бөгөөд нийт ус сувгийн дундаж өртөг 2979 төгрөг, борлуулалтын дундаж үнэ 1594 төгрөг байна. Эндээс харахад ус сувгийн албаны борлуулалт нь дундаж өртгөөсөө бага үнээр борлогдож алдагдалтай ажиллаж байна.

Нүүрс олборлон борлуулах аж ахуй нэгж байгууллагуудаас аль болох хямд үнэтэй, чанарын шаардлага хангасан нүүрс худалдан авах, цалин хөлс, тээврийн зардал болон бусад зардлыг бууруулснаар борлуулсан бүтээгдэхүүний өртгийг бууруулах боломжтой байна.

Аудитын явцад ОНӨҮГ-ын борлуулсан бүтээгдэхүүний өртгийг бууруулснаар гарах үр ашгийн тооцоо судалгааг хийлээ.

Үр ашгийн тооцоо

№	Үзүүлэлт	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/
1	Орон тоо цөөрүүлснээр	63,6
2	Тээврийн хөлсний зардлыг хэмнэснээр	16,0
3	Нийтийн бие засах газрын зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлснээр	16,7
4	Цайны газрыг түрээсээр ажлуулснаар	7,3
5	Цэвэр усны үнийг нэмэгдүүлснээр	150,0
	Нийт	253,6

2.6 Өр авлагыг барагдуулах ажил үр дүнтэй хэрэгжиж байна уу?

Оны эхнээс авлага 98,2 сая төгрөгөөр, өглөг 176,1 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Тус байгууллагын дансны авлага өглөгийг сүүлийн 3-н жилийн байдлаар судалж үзэхэд авлага 2011 оноос /127.3-340.5/ 213.0 сая төгрөг буюу 267 хувиар, 2012 оноос /242.2-340.5/ 98.3 сая төгрөг буюу 140 хувиар өсч 340.5 сая төгрөг байгааг тодруулбал төсөвт байгууллагаас авах авлага өмнөх оноос 126.1 сая төгрөгөөр өсч 217.3 сая төгрөг болж нийт авлагын 68.3 хувийг эзэлж байгаа нь авлага нэмэгдүүлэхэд голлон нөлөөлсөн байна. ААНБайгууллагын авлага 13.9 сая төгрөгөөр өсч, айл өрхийн авлага 5.3 сая төгрөгөөр буурч, бусад авлага 36.4 сая төгрөгөөр буурсан байна.Төсөвт байгууллагын авлагыг байгууллагаар нь судалж үзвэл Хүмүүн цогцолбор сургууль 77.9 сая төгрөг, Хүүхдийн байгууллага 41.7 сая төгрөг, Зуунмод сумын цэцэрлэгүүд 27.1 сая төгрөг, Соёл спорт аялал жуулчлалын газрын угсаатны музей 34.0 сая төгрөг, 4-р сургууль 8.3 сая төгрөг, 5-р сургууль 8.2 сая төгрөг, ЭМГазар 6.8 сая төгрөг, Онцгой байдлын хэлтэс 4.5 сая төгрөг буюу байгууллагууд төсөвт байгууллагуудаас авах авлагын ихэнхийг эзэлж байна.

ААНБайгууллагуудаас авах авлага өмнөх оны мөн үеэс 13.9 сая төгрөгөөр өсч 68.7 сая төгрөг болж өссөнийг байгууллагаар нь авч үзвэл Их наяд ХХКомпани 11.7 сая төгрөг, ҮЭХолбоо 10.4 сая төгрөг, Их хайрхан богд ХХК 7.2 сая төгрөг, МАН-ын хороо 6.3 сая төгрөг, Максимум ХХК 5.5 сая төгрөг, Эмэгтэйчүүдийн зөвлөл 4.9 сая төгрөг, Морьтхангай ХХК 4.5 сая төгрөгийн авлагатай бөгөөд дийлэнх хувийг эзэлж байна. Айл өрхөөс авах авлага 5.3 сая төгрөгөөр буурсан нь сайн үзүүлэлт боловч 28.4 сая төгрөгийн авлага байгааг хойшид анхаарч ажиллах шаардлагатай.

Авлага өглөгийн судалгаа

Үзүүлэлтүүд	Оны эхэнд	Оны эцэст	Хэтрэлт хэмнэлт
Авлага	242.4	340.5	-98.2
<i>Төсөвт байгууллагаас</i>	91.2	217.3	-126.1
<i>ААНБ-аас</i>	54.8	68.7	-13.9
<i>Айл өрхөөс</i>	33.7	28.4	-5.3
<i>Бусад байгууллага</i>	59.2	9.8	49.4
<i>Хувь хүнээс</i>	3.1	5.6	2.5
<i>Түлээ нүүрсний</i>		9.5	9.5
Өглөг	718.7	894.8	176.1
<i>ААН Байгууллагад</i>	478.3	540.9	-62.7
<i>Хувь хүнд</i>		2.6	2.6
<i>Татварт</i>	34.7	77.5	42.8
<i>НДШ</i>	12.2	-	12.2
<i>УООрлого</i>	190.3	84.0	106.3
<i>ХБОрлого</i>		159.3	159.3

2013 оны санхүүгийн тайлангаар 894.8 сая төгрөгийн өглөг байгаа нь 2011 оноос /318.8-894.8/ 576.0 сая төгрөгөөр, 2012 оноос /718.7-894.8/ 176.1 сая төгрөгөөр буюу 124 хувиар өссөн байна. Энэхүү 894.8 сая төгрөгийн өглөгийг бүтцээр нь авч үзвэл ААНБайгууллагад өгөх өглөг 540.9 сая төгрөг буюу 60 хувийг, Зуунмод сумын сургууль, цэцэрлэгийн хойшлогдсон борлуулалтын орлогын өглөг татварын хамтаар 159.3 сая төгрөг буюу 18 хувь, ХХОАТ болон НӨАТ-ын өглөг 77.5 сая төгрөг, бусад өглөгийн хувьд Архуст, Зуунмод сумдын цэвэрлэх байгууламжийн 73.2 сая төгрөгийн, өндөр настнуудын тэтгэмжинд 17.2 сая төгрөг, Зуунмод сумын иргэдийн хямд түлээ нүүрсний үнэ 10.7 сая төгрөгний өглөг тус тус байна. ААНБайгууллагын өглөг 540.0 сая төгрөгийг тодруулбал Петрокоаль ХХК-д 187.7 сая төгрөг, аймаг хөгжүүлэх санд 110.8 сая төгрөг, ШивээОвоо ХХК-д 85.9 сая төгрөг, Багануур илч ХХК-д 64.9 сая төгрөг, Арбаянгол ХХК-д 44.1 сая төгрөг, Багануур сувилал ХХК-д 6.6 сая төгрөгийн тус тус өглөгтэй байна. Энэхүү өглөг нь борлуулалтын орлогын 38.8 хувийг эзэлж, авлагаасаа /340.5-894.8/ 554.0 сая төгрөгөөр буюу 2.5 дахин их байгаа нь байгууллагын мөнгөний эргэлт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Мөн ХХОАТатварын 45.7 сая төгрөг, НӨАТатварын 31.9 сая төгрөг, нийт 77.6 сая төгрөгийн татварын өрийг цаг тухайн үед төлөх боломж байсан төдийгүй энэ хэмжээгээр төсвийн орлого

саатуулсан зөрчил байна. Төв аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2013 оны 5-р сарын 08-ны өдрийн 02 тоот тогтоолоор Зуунмод сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны үнийг 2013.09.15-наас эхлэн нэмэгдүүлэн тогтоож төсөвт байгууллагын 1м3 дулааны үнийг /нөат-гүй/ 1900 төгрөгөөр тогтоосон үнийг бүх байгууллагад мөрдөн борлуулалт хийж нэхэмжилж тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан 159.3 сая төгрөгийн авлагыг оны эцэст Зуунмод сумын зарим сургууль, цэцэрлэгийн төсвийг тодотгоогүй хүрэлцэхгүй гэсэн шалтгаанаар аймгийн зарим удирдлагын аман шийдвэрээр хойшлогдсон борлуулалтын орлогоор бүртгэж, өглөг үүсгэн бүртгэжээ. Үнийн өөрчлөлтөөс үүссэн өрийн тооцоо судалгааг БШУЯ-д хүргүүлэхэд “Төсвийн ерөнхийлөн захирагч болон аймгийн Засаг дарга хооронд байгуулсан Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний 3.9.8-д төсвийн жилийн дундуур тогтмол зардлын үнийг нэмэгдүүлэхгүй байх үүрэгтэй тул уг өрийг тодотголоор шийдвэрлэх боломжгүй” гэсэн хариу ирүүлжээ. Энэ нь “Төсвийн тухай” хуулийн 6.2.3-т “урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдснээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх” гэсэн заалт зөрчигдсөн байгаа тул уг асуудлыг холбогдох байгууллагад нь тавьж шийдвэрлэх шаардлагатай байна.

Төв аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 84 тоот “Төв Чандмань ДЭХГ” ОНӨҮГ-ын өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай тогтоолын 2.2-д “аймгийн төсөвт байгууллагуудын “Төв Чандмань ДЭХГ” ОНӨҮГ-т төлөх 167,0 сая төгрөгийн өрийг барагдуулах арга хэмжээг энэ оны 8 дугаар сард авч хэрэгжүүлэх гэж заасан боловч төсвийн байгууллагууд нилээд өртэй уг заалт хэрэгжээгүй байна.


2.7 Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт үр нөлөөтэй хэрэгжиж үү?

Өмч хөрөнгөнд бүртгэлтэй дулааны станцын болон уурын зуухны барилга, тоног төхөөрөмжүүд ашиглалтгүй байна.

2013 оны жилийн эцсээр нийт хөрөнгийн дүн 9556.8 сая төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 979.8 сая төгрөг үүнээс 479.7 сая төгрөгийн бараа материал, эргэлтийн бус хөрөнгө 8577.0 сая төгрөгийн хөрөнгө тайлагнагдсан байна. Тайлант онд барилга байгууламж 393.3 сая төгрөг, тоног төхөөрөмж 879.8 сая төгрөг, тээврийн хэрэгсэл 76.9 сая төгрөг, тавилга эд хогшил 1.3 сая төгрөг нийт 1281.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, 87.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг аймгийн ИТХурлын 2013 оны 10-р сарын 13-ны 95 тоот тогтоолын дагуу акталж данснаас хассан байна. Нэмэгдсэн үндсэн хөрөнгийг эх үүсвэрийн байдлаар нь авч үзвэл 696.6 сая төгрөгийн хөрөнгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, 566.3 сая төгрөгийг орон нутгийн хөрөнгө оруулалтаар, бусдыг өөрийн хөрөнгөөр тус тус бэлтгэжээ. Акталсан хөрөнгийг тодруулбал барилга байгууламж 12.0 сая төгрөг, машин тоног төхөөрөмж 70.6 сая төгрөг, тээврийн хэрэгсэл 1.5 сая төгрөг, тавилга эд хогшил 3.1 сая төгрөгийн хөрөнгө данснаас хасагдсан байна. Үндсэн хөрөнгийг актлах асуудлыг жил бүр эрх

бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлээгүйгээс 2013 онд ихээхэн хэмжээний 87.3 сая төгрөгийн хөрөнгийг аталж данснаас хассан дүнгээр байгууллагын алдагдлыг 50.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Эргэлтийн хөрөнгийн хөдөлгөөний байдлыг судалж үзвэл оны эхэнд 365.2 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл дээр 1403.5 сая төгрөгийн нүүрс, 163.9 сая төгрөгийн хангамжийн материал, 6.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 6.1 сая төгрөгийн автын сэлбэг, 148.4 сая төгрөгийн шатах тослох материал нийт 1728.9 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө худалдан авч, 1614.4 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд зарцуулж, оны эцсийн тайлангаар 479.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагийн дийлэнх хувийг 10668 тн буюу 286.9 сая төгрөгийн нүүрс, 141.2 сая төгрөгийн ашиглалтанд буй тоног төхөөрөмж эзэлж байна. Үндсэн ба эргэлтийн хөрөнгийг жилийн эцэст ТБОНӨ-ийн тухай хуулийн 73-р зүйлийн дагуу тооллого хийж тооцоог бодон нягтлан бодох бүртгэлийн тайланд тусгасан байна. Нөөцөлсөн нүүрсийг тоолж, үлдэгдлийг үнэн бодитой гаргах, тухайн тайлант хугацаанд нүүрсний зардлыг бодит хэмжээнд тооцон гаргахад мөрдөх журмыг боловсруулан мөрддөг бөгөөд үүний дагуу нүүрсний хэмжээг тооцож, тооллого хийсэн байна.



Байгууллагын нийт өмч хөрөнгийн тооллого тооцоо бодолт хөрөнгийн карт хөтлөлт, данс бүртгэл хөтлөлт зохих хууль, журмын дагуу хийгдсэн байна. Акталсан үндсэн хөрөнгөөс 19.3 сая төгрөгийн нэг бүрийн үнэ бүхий ДТХ-4 тогоо 2 ком, зуухны яндан ф-1000, комперосер, сэнс, насосууд, трактор, модон хашаа зэргээс эргүүлэн ашигласан болон худалдан борлуулсан эсэхийг тодруулахад 3-р зуухны тогооны зарим хэсгээр 6-р зуухны нүүрсний хашаа барьсан гэхээс өөр ашигласан борлуулсан зүйл байхгүй байна.

Зуунмод суманд 1999 онд баригдсан төвлөрсөн уурын зуухны станцын барилга 234.8 сая төгрөгөөр “Дуусаагүй барилга” нэрээр бүртгэлтэй, ашиглалтгүй хөрөнгө байна. Энэхүү ашиглагдахгүй байгаа хөрөнгийн өмчлөл ашиглалт эзэмшилтийн асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад нь тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1.Тус байгууллага нь төсөвт байгууллага, аж ахуйн нэгжүүд, айл өрхүүдэд дулаан хангамж, сувагжуулалт, цэвэр бохир ус, СӨХ-ийн үйлчилгээг үзүүлэх үндсэн үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

2.Төлөөлөн удирдах зөвлөл нь зардал хэмнэх зарчим, боломжийг нарийвчлан судалж дүгнэлт хийлгүйгээр байгууллагын орлого зарлагын төлөвлөгөөг алдагдалтай байхаар баталж байгаа нь Компаний тухай хуулийн 76 дугаар зүйл, ОНӨҮГазрын Удирдах зөвлөлд төлөөлөл хэрэгжүүлэх журмын 2.8, 3.5 дахь заалт, ОНӨҮГазрын дүрмийн 7-р зүйл заалтыг тус тус зөрчсөн байна.

3. 2013 онд үйл ажиллагааны үр дүн нь төсвөөс алдагдал нөхөхөд 163.5 сая төгрөг олгож үндсэн үйл ажиллагаа нь ашигтай гарсан боловч, үйл ажиллагааны бус алдагдалд 50.9 сая төгрөгийн акталж данснаас хассан хөрөнгийн үнэ нөлөөлснөөр балансын дүнгээр 25.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

4. Байгууллагын борлуулалтын орлогын 85 хувийг төсөвт байгууллага, 15 хувийг аж ахуйн нэгж, айл өрх эзэлж, нийт зардлын 37.8 хувийг цалин шимтгэлийн зардал, 36.7 хувийг нүүрсний зардал, 12.5 хувийг тээврийн зардал, 7.3 хувийг цахилгааны зардал, 5.7 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

5. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээр 2,3,4-р халаалтын зуухны тогоо, тоног төхөөрөмжинд 1262.9 сая төгрөгийн техник технологийн шинэчлэл хийснээр зуухны дулаан үйлдвэрлэх техникийн хүчин чадал нэмэгдэж, хөдөлмөрийн бүтээмж, ажиллах нөхцөл сайжирч, халаах талбайн хэмжээ 25.7 мянган м3-ээр нэмэгдэн, 1м3 талбайг халаах нүүрсний хэмжээ 1.8 кг-аар буурсан боловч нүүрсний үнэ нэмэгдснээс 1м3 талбайг халаах зардал буураагүй байна.

6. Дулаан хангамжийн нэгж талбайн үнэ тарифийг Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс нэмэгдүүлж 2013 оны сүүлийн хагас жилээс мөрдөж эхэлснээр албан байгууллагуудын дулааны борлуулалтын орлого 353.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Дулааны үнийг нэмэгдүүлчихээд зарим төсөвт байгууллагын төсөвт тодотгол зохицуулалт хийгээгүйгээс 159.3 сая төгрөгийн авлагыг хойшлогдсон борлуулалтын орлогоор бүртгэж энэ хэмжээгээр өглөгийг өсгөсөн байна.

7.Борлуулсан бүтээгдэхүүний өртөг тооцохдоо удирдлагын, борлуулалтын, үйл ажиллагааны бус зардлыг оруулан тооцож байна.

8. Үйл ажиллагааны бус орлого зарлагыг оны эхнээс төлөвлөн Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулж ажиллаагүйгээс алдагдалтай ажиллаж төлөвлөгдөөгүй үргүй зардал гаргаж байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон Гүйцэтгэх захирал Г. Цогтсайхан нарт зөвлөх нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс Компаний тухай хууль болон бусад хууль, тогтоомж, дүрэм, журмыг мөрдөн ажиллаж жилийн орлого зарлагын төлөвлөгөөг хэлэлцэн батлахдаа алдагдалтай бус ашигтай ажиллах зарчмыг баримтлан ажиллаж, үйл ажиллагааны үр дүнг жил бүр хэлэлцэн шийдвэрлэж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах
2. 2,3,4-р зуухны ус халаалтын тогоо, тоног төхөөрөмжийн технологийн шинэчлэл хийсний үр дүнгээр нүүрсний болон хөдөлмөрийн зардлыг бууруулах арга хэмжээг авах
3. Байгууллагын албадуудын зарим хавсран гүйцэтгэж болох боломжтой орон тоо, ажлын байрыг нягтруулах, нүүрсийг өөрийн байгууллагын тээврээр тээвэрлэх зэргээр цалин шимтгэл, тээврийн зардлыг бууруулах
4. Аж ахуйн нэгж, төсөвт байгууллага, орон сууцны айл өрхийн хэрэглэх цэвэр, бохир усны өнөөгийн мөрдөж байгаа нэгжийн үнийг нэмэгдүүлэх, тоолууржуулах асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх замаар цэвэр усны алдагдлыг бууруулах арга хэмжээ авах.
5. 2013 оны сүүлийн хагас жилийн халаалтын улиралд нэмэгдсэн үнээр борлуулсан дулааны борлуулалтын орлогоос зарим төсөвт байгууллагаас авах 159.3 сая төгрөгийн авлагыг хойшлогдсон борлуулалтын орлогоор бүртгэж өглөгөөр тайлагнасныг залруулах буюу байгууллагын нийт өр, авлага өсч байгаад дүгнэлт хийж бууруулах талаар тодорхой ажил зохион байгуулах
6. Үйл ажиллагааны бус орлого зарлагыг нарийвчлан төлөвлөж гүйцэтгэлээр ашигтай ажиллах зарчмыг баримтлан хэрэгжүүлэн ажиллах
7. Нийт зардлаас удирдлагын зардал болон борлуулалтын зардлыг хасч цэвэр үйлдвэрлэлийн зардлын дүнгээс борлуулсан бүтээгдэхүүний өртгийг тооцон төлөвлөж, тайлагнаж ажиллах
8. Ашиглалтгүй байгаа дулааны станцын барилга болон бусад зуухны барилга, тоног төхөөрөмж, шугамын өмчлөл, ашиглалт, эзэмшлийн асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх
9. Аймгийн ИТХТ-ийн 2006 оны 101 тоот тогтоолын 2-т “Нийтийн бие засах газрын эд хөрөнгийг актаар хүлээлцүүлж, ажиллуулах зардлыг жил жилийн төсөвтөө тусган санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргад даалгасугай” гэсэн заалтыг хэрэгжүүлэх

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал